

“АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ¹

УДИРТГАЛ

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.22-д “Хууль зүйн судалгааны чанарыг шинэ түвшинд гаргаж, хууль тогтоомжийн боловсруулалт, хэрэгжилтийг судалгаанд суурилан хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ” гэж, мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлнэ” гэж тус тус заасан.

Энэхүү үнэлгээний зорилго нь Засгийн газраас баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийг /цаашид “төсөл” гэх/ боловсронгуй болгоход оршино.

Түүнчлэн судалгаагаар төслийн үр нөлөөг үнэлж, уг төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн эрх зүйн орчныг сайжруулах боломжийг тодорхойлох, мөн хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэхийг зорилоо.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслийн үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонгосон:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Харилцан уялдаа.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн:

1. Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хөгжлийн хурдац,

¹ Энэхүү үнэлгээг УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалангийн захиалгаар 2019 онд ХЗҮХ-ийн ЭНБД, хууль зүйн доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ажилтан Э.Уянга, Д.Цэцэгдарь нар хамтран гүйцэтгэв.

үүнээс үүдэн гарсан нөхцөл байдал, хууль тогтоомжийн чанарыг сайжруулахад чиглэсэн² байх гэсэн үндсэн зорилгод хүрсэн эсэх.

2. Уг төсөлд тусгагдсан, санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хангасан зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх;

3. Төсөлд тусгагдсан зохицуулалтуудыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэх;

4. Төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан эсэхийг тус тусад нь шалгана.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООХ

Энэхүү хэсэгт уг төслийн үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Төслийн үндсэн зорилго нь Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хөгжлийн хурдац, үүнээс үүдэн гарсан нөхцөл байдал, хууль тогтоомжийн чанарыг сайжруулахад чиглэсэн³ байна. Энэ зорилгод хүрэхийн тулд дэвшүүлсэн зорилтуудыг нэгтгэн дараах байдлаар тогтоосон.

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үндсэн зарчим, журмыг улам тодорхой болгох,
- Тусгайлсан хууль боловсруулах,
- Үндсэн хуульд заасан иргэний сонгох эрхийг хангах,
- Сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулах.

Иймд хуулийн төслийн дээрх зорилтуудтай холбогдсон зүйл, заалтыг сонгон авч “зорилгод хүрэх байдал”-ын үр нөлөөг тооцох болно. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл, заалт
1.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үндсэн зарчим, журмыг улам тодорхой болгох,	6 дугаар зүйл, 3.1.5, 6.13, 9.11, 14.5, 16.2.10, 16.2.13, 17.3.13, 18.2.4, 19.12, 19.16, 20.19, 20.20, 20.23, 21 дүгээр зүйлийн нэр, 22.3.5, 22.4.5, 23.6.6, 26 дугаар зүйл, 31.1, 33.6, 43.17, 44.8, 67.2, 67.5, 69.13, 70.4, 73.6, 73.7, 75.3, 77.9, 77.15, 77.18, 84.2, 84.5, 85.2, 87.1, 87.5, 87.6, 11 дүгээр бүлгийн нэр
2.	Тусгайлсан хууль боловсруулах,	1 дүгээр зүйл

² Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд туссан зорилгыг аргачлалын дагуу шалгав.

³ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд туссан зорилгыг аргачлалын дагуу шалгаж үзлээ.

3.	Үндсэн хуульд заасан иргэний сонгох эрхийг хангах,	4.1, 5 дугаар зүйл,
4.	Сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулах.	Гуравдугаар бүлэг

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд, санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хангасан зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх, талаарх зохицуулалтыг сонгон “Практикт хэрэгжих байдал”-ын үр нөлөөг нь тооцох болно.

Хүснэгт 2. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл, заалт
1.	Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хангасан зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх	68.5.Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна, 68.4.Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг төслийн зүйл, заалт хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгаж тогтооно. /Хуулийн төсөл нь 12 бүлэг, 89 зүйлтэй/

2.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн уялдаа холбоо хангагдсан эсэхийг шалгаж тогтооно. /Хуулийн төсөл нь 12 бүлэг, 89 зүйлтэй/

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 3. Шалгах хэрэгслийг сонгосон байдал

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
---	------------------	------------------------	-------------------------

1.	Зорилгод хүрэх байдал	6 дугаар зүйл, 3.1.5, 6.13, 9.11, 14.5, 16.2.10, 16.2.13, 17.3.13, 18.2.4, 19.12, 19.16, 20.19, 20.20, 20.23, 21 дүгээр зүйлийн нэр, 22.3.5, 22.4.5, 23.6.6, 26 дугаар зүйлийн нэр, 31.1, 33.6, 43.17, 44.8, 67.2, 67.5, 69.13, 70.4, 73.6, 73.7, 75.3, 77.9, 77.15, 77.18, 84.2, 84.5, 85.2, 87.1, 87.5, 87.6, 11 дүгээр бүлгийн нэр	Зорилгод дүн шинжилгээ хийх
		1 дүгээр зүйл	
		4.1, 5 дугаар зүйл,	
		Гуравдугаар бүлэг	
2.	Практикт хэрэгжих боломж	68.4, 68.5 дахь хэсэг	Практикт тухайн төрлийн харилцаа, чиг үүргийг хэрэгжих боломж, гарч болох хүндрэлийг судлах.
3.	Ойлгомжтой байдал	Төслийг бүхэлд нь тооцно.	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах.
4.	Харилцан уялдаа	Төслийг бүхэлд нь тооцно.	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар шалгах.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

3.1. Зорилгод хүрэх байдал

“Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хөгжлийн хурдац, үүнээс үүдэн гарсан нөхцөл байдал, хууль тогтоомжийн чанарыг сайжруулахад чиглэсэн” зорилгод хүрэхийн тулд дэвшүүлсэн зорилтуудад дараах байдлаар дүн шинжилгээ хийж үзлээ:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үндсэн зарчим, журмыг улам тодорхой болгох, /6 дугаар зүйл, 3.1.5, 6.13, 9.11, 14.5, 16.2.10, 16.2.13, 17.3.13, 18.2.4, 19.12, 19.16, 20.19, 20.20, 20.23, 21 дүгээр зүйлийн нэр, 22.3.5, 22.4.5, 23.6.6, 26 дугаар зүйл, 31.1, 33.6, 43.17, 44.8, 67.2, 67.5, 69.13, 70.4, 73.6, 73.7, 75.3, 77.9, 77.15, 77.18, 84.2, 84.5, 85.2, 87.1, 87.5, 87.6, 11 дүгээр бүлгийн нэр/

Төслийн 6 дугаар зүйлд сонгуулийн үйл ажиллагаанд баримтлах зарчмыг хуульчилжээ. Нийтлэг зарчим болох сонгох, сонгогдох эрхийг хангах, хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж, саналаа нууцаар гаргах, хууль дээдлэх, ил тод байдлыг хангах, шударга ёсыг сахих, сонгуулийн үйл ажиллагаа товлосон хугацаанд эхэлж, дуусах зэргийг тусгасан.

Харин төслийн 6.4 дэх хэсэгт хориглосон зохицуулалт, 6.7, 6.8 дахь хэсэгт сонгуулийн хугацаа, 6.9 дэх хэсэгт сонгогчийн саналаа нууцаар гаргах эрх сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчимд хамаарахгүй тухай, 6.10, 6.11 дэх хэсэгт

үүрэгжүүлсэн зохицуулалт, 6.12 дахь хэсэгт ТББ эрхийн талаар, 6.13 дахь хэсэгт сонгуулийн төв байгууллагын журам батлах тухай, 6.14 дэх хэсэгт хориглосон зохицуулалтад ногдуулах торгуулийн хэмжээг заасан байгааг зарчимд хамааруулан үзсэн нь зарчмыг тодорхой болгосон гэж үзэх үндэсгүй байна.

Төслийн 3.1.5, 6.13, 9.11, 14.5, 16.2.10, 16.2.13, 17.3.13, 18.2.4, 19.12, 19.16, 20.19, 20.20, 20.23, 21 дүгээр зүйлийн нэр, 22.3.5, 22.4.5, 23.6.6, 26 дугаар зүйл, 31.1, 33.6, 43.17, 44.8, 67.2, 67.5, 69.13, 70.4, 73.6, 73.7, 75.3, 77.9, 77.15, 77.18, 84.2, 84.5, 85.2, 87.1, 87.5, 87.6, 11 дүгээр бүлгийн нэрэнд журамтай холбоотой зохицуулалт тусгагдсан.

Ийнхүү тусгахдаа, "...*тухай хуулийн 141-143 дугаар зүйлд заасан журмын дагуу...*", "Энэ хуулийн 6.12-д заасан үйл ажиллагааг зохицуулах журмыг ...*батална*", "...*хоногийн ням гарагт улс даяар нэгдсэн журмаар явагдана.*", "сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох журмыг... *батална.*", "...*зохих журмын дагуу*", "Сонгуулийн ерөнхий хорооноос *баталсан журмын дагуу*", "санал авах өдрөөс 26-аас доошгүй хоногийн өмнө ирүүлж, энэ хуульд заасан журмын дагуу бүртгүүлж болно", "Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, *хяналт тавих журмыг ...баталж, мөрдүүлнэ*", "Саналын хуудас нь санал авах өдөр хүртэл, санал авч эхэлснээс хойш санал тоолж дуусах хүртэл, санал авах ажиллагаа дууссанаас хойш *холбогдох журмын дагуу*", "Нөхөн сонгуулийг энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна.", "Энэ хуульд заасан зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан харъяалал, *журмын дагуу* хянан шийдвэрлэнэ", "Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлд заасны дагуу тусгай журмаар шийдвэрлэх", "21 дүгээр зүйлийн нэр *Сонгогчдын нэрийн жагсаалттай холбогдсон гомдлыг шийдвэрлэх журам*", "26 дугаар зүйлийн нэр нь *Нэр дэвшүүлэх нийтлэг журам*", "нэвтрүүлэх талаар энэ хуулийн 43.17-д заасан журам зөрчсөн", бүлгийн нэр нь "Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, гомдол маргаан хянан шийдвэрлэх харъяалал, журам" зэргээр зохицуулсан байгаа нь ямар журмыг тодорхой болгож байгаа нь ойлгомжгүй байна.

Зорилгод хүрэх эхний зорилт тодорхойгүй, ойлгомжгүй байх тул зорилгод хүрсэн гэж үзэх үндэсгүй байна.

Тусгайлсан хууль боловсруулах, /хуулийн төслийн 1 дүгээр зүйл/
--

Хуулийн төслийн үзэл баримтлалд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийг сонгуулийн харилцааны онцлогийг тусгасан, бүхэлд нь боловсронгуй болгох, Сонгуулийн тухай хуулиас тусгайлсан хуулийн төсөл боловсруулах талаар тусгасан. Иймд хуулийн төслийн 1 дүгээр зүйлд дүн шинжилгээ хийж үзлээ.

Сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулах талаар 1996, 2007, 2012, 2015 оны хуулиудын зорилтод заасан байна. Мөн энэхүү Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл, бусад тусгайлсан хуулийн төсөл болох УИХ-ын сонгуулийн тухай, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухайд зорилтод ижил зохицуулжээ.

Сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбоотой харилцааг тусгайлсан хуулиар зохицуулсан байдаг. Өөрөөр хэлбэл, сонгуулийг зохион байгуулж явуулах ажлыг Сонгуулийн төв байгууллага буюу сонгуулийн төв хороо хариуцах бөгөөд энэ тухай 2006 онд батлагдсан Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиар зохицуулдаг. Энэ хуулийн 1

дүгээр зүйлд заасан Хуулийн зорилтод “сонгуулийн төв байгууллагын эрх зүйн байдал, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах” талаар тусгасан байгаа нь хууль хоорондын давхардлыг үүсгэж байна.

Аливаа хуулийн зорилтод тухайн хуулиар зохицуулагдах харилцааны хамгийн товч хэлбэрийг тусгасан байдаг бөгөөд энэхүү хуулийн төслийн зорилтоос үзвэл *сонгуулийг зохион байгуулж явуулах тухай* зохицуулж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулиар заагдсан сонгох, сонгогдох эрх хэрхэн хангагдах, үндсэн зарчмыг хэрхэн тодорхой болгож байгаа нь ойлгомжгүй байна.

Манай улсын болон олон улсын эрдэмтэн судлаачид⁴ 2002 онд “Монгол Улсын сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь” олон улсын бага хурлаар “Сонгуулийн хууль тогтоомжийг улс эх орныхоо язгуур эрх ашиг, нийтийн эрх ашгийг хангах, урт удаан хугацаанд үйлчлэх тогтвортой сайн хуультай болох үүднээс боловсруулах нь зүйтэй юм. Сонгуулийн хууль ард түмэнд хамгийн ойлгомжтой, энгийн бөгөөд тэдний эрхийг дээд зэргээр хангасан байх” тухай хэлэлцэж байсан.

Мөн сонгуулийн хууль, сонгуулийн тогтолцооны үүсэл хөгжил, төлөвшил болон бүхий л асуудлыг нухацтай авч үзсэн байх бөгөөд энэ үед сонгуулийн тогтолцоог сонгох, түүний эрх зүйн үндсийг бүрдүүлэх, сонгууль явуулах ажилтныг бэлтгэх, сонгогчдын улс төрийн боловсролыг дээшлүүлэх нь тулгамдсан асуудал байжээ.

1992 оноос 2019 он буюу 27 жилийн дараа *тусгайлсан хуулийн төслүүдийг* хэлэлцэх хэлэлцүүлгийн⁵ явцад мөн л эдгээр тулгамдсан асуудал хэвээр байгааг оролцогсод онцолж байсан. Мөн *тусгайлсан хуулийн төслүүдийг* давхардуулсан байгаа тухай дурдаж байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Сонгуулийн тухай хуулиар УИХ, Ерөнхийлөгч, Орон нутаг гэсэн үгээр ялгаатай агуулгын хувьд давхардсан зохицуулалт олон байдаг. Хуулийн төслийн үзэл баримтлалд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Сонгуулийн тухай хуулийн ерөнхий зарчмыг баримтлан орон нутгийн Хурлын сонгуулийн харилцааны онцлогийг тусгасан бие даасан хуулийн төслийг боловсруулах талаар тусгасан хэдий ч Сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл нь цөөхөн зохицуулалтаар ялгаатай болжээ. Өөрөөр хэлбэл, хуулийн ихэнх зохицуулалтыг хуулбарлах байдлаар боловсруулсан төдийгүй тусгайлсан 3 хуулийн төсөл хоорондын давхардлыг үүсгэх бөгөөд ялгаатай зохицуулалтыг олж харахад төвөгтэй байдлыг үүсгэж байна.

Иймд Сонгуулийн тухай хуулийг өөрчлөн тусгайлсан хуулиудыг гаргахаар зорьж байх тул эдгээр хуулийн төслөөр /УИХ, Ерөнхийлөгч, АНСДИТХ/ тусгайлсан онцлог зохицуулалтыг тусгах буюу нэгэнт хууль боловсруулж байгаагаар холбогдуулан Сонгуулийн тухай хуульд /ерөнхий хууль/ Сонгуулийн төв байгууллагын тухай хууль буюу үйл ажиллагаа, зохион байгуулалтыг зохицуулсан байгаа Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийг нэмж зохицуулан харин санхүүжилтийн асуудлыг тусдаа хуулиар зохицуулан сонгуультай холбоотой 5 тусгайлсан хуулийг боловсруулан давхардсан зүйлгүй ойлгомжтой энгийн байдлаар сонгох, сонгогдох эрхийг ханган, урт удаан хугацаанд тогтвортой үйлчлэх, сайн хуулийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

⁴ “Монгол Улсын сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь” олон улсын бага хурлын эмхэтгэл. Эмхэтгэсэн, Ж.Ядамсүрэн. Уб., 2002 он.

⁵ Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцүүлэг. Уб., 2018 он.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн ...шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг 18 наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгазан хуулиар тогтооно.”⁶ гэж заажээ. Ийнхүү МУҮХ батлагдсанаас хойш сонгогчид сонголтгоо хийх бүрэн эрхээр хангагдсан төдийгүй бүх шатны сонгуульд оролцох эрхтэй болсон.

Хуулийн төслийн 4.1 дэх хэсэгт “Орон нутгийн Хурлын сонгууль нь Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, тухайн нутгийн өөрөө удирдах байгууллагыг өөрсдийн төлөөллөөр бүрдүүлэх үндсэн арга мөн.” гэж сонгох эрхийг хангах үндсэн зарчмыг тунхаглажээ. Харин 5 дугаар зүйлд Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг 8 хэсэгт хуваан зохицуулжээ. Сонгуулийн эрх бүхий иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр сонгох эрхтэй.

Орон нутгийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдох эрхийг хорин таван нас хүрсэн, тухайн аймаг, нийслэл, суманд санал авах өдрөөс өмнө 180-аас доошгүй хоногийн хугацаанд тасралтгүй, байнга оршин суугчаар бүртгүүлсэн, хуулиар заасан бусад шаардлагыг хангасан иргэн байх тухай заасан. Харин хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 4 заалтад хориглосон, эрхгүй байх тухай, хариуцлагын заалтыг тусгасан байгаа нь зүйлийн нэртэй нийцэхгүй байна. Иймд сонгох, сонгогдох эрхийг хангах зохицуулалт туссан хэдий ч зорилтод хүрсэн гэж үзэхгүй байна.

Сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулах. /Гуравдугаар бүлэг, 14-19 дүгээр зүйл/

Хуулийн төслийн 14.2-т Сонгуулийн ерөнхий хороо нь орон нутгийн Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулахад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах тухай зохицуулсан бол Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3-т Сонгуулийн ерөнхий хороо нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажлыг хангахад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах тухай заасан байна. Мөн энэ хуулийн төслийн зорилтоос эхлэн ихэнх зохицуулалт зохион байгуулалтыг хангасан байх тул сайжруулахад нэлээд анхаарсан зэрэг нь хэлэлцүүлэгт дурдсан байгаагаас харж болох юм. Иймд дээрх зорилтыг хангасан гэж үзэх үндэслэлтэй юм.

3.2. Практикт хэрэгжих боломж

Судалгааны багийн зүгээс “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үр нөлөөг тооцох хэсгийг тогтоохдоо цахим хуудас дахь мэдээлэл, судлаачдын судалгаа, мэдээллийг судлах замаар шалгасан.

⁶ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл 1992 оны №1.

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хангасан эсэхийг хуулийн төслийн 68.4, 68.5-т заасныг сонгон авч үнэлэлт өгөхийг зорилоо. Ингэхдээ дараах асуултад хариулахыг эрмэлзлээ.

1. Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх;
2. Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд боломж бололцоо байгаа эсэх.

68.4.Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.

68.5.Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна

1. Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх:

Төслийн 68.4-т “Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна”, 68.5-т “Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна” гэж заасан байна.

СЕХ нь иргэдийг санал өгөх эрхээ эдлэх боломжоор хангахын тулд нэлээдгүй хүчин чармайлт гаргасан байдаг бөгөөд хамгийн сүүлийн 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулиас авч үзвэл сонгуулийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал өгөх нөхцөлийг хөнгөвчлөх хүчин чармайлтуудыг гаргаж байсан хэдий ч санал авах олон байр хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс ороход хүндрэлтэй хэвээр байжээ.⁷

Хууль эрх зүйн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хүлээн зөвшөөрч, улс төрийн намуудад сурталчилгааны материалаа тэдэнд хүртээмжтэй болгох, мөн хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчдэд дэмжлэг үзүүлэх зэрэг үүргийг заажээ⁸. Гэвч зарим төрлийн сэтгэцийн эрүүл мэндийн эмгэгтэй сонгогчдын санал өгөх эрхийг эрх зүйн чадамжгүй гэх өргөн хүрээтэй ойлголтод хамаатуулан хязгаарлаж байгаа нь НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн зарчим, үзэл санаанд нийцэхгүй байна. АН болон МАН-аас нэр дэвшигчид хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, амьдралын чанарын талаар тусгажээ. СЕХ нь Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ)-тай хамтран харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулан сонгогчдын боловсролд чиглэсэн сонгуулийн материалуудыг гаргаж, мөн сонгогчдод зориулсан видео бичлэгтээ дохионы хэлийг нэмж оруулсан. Олон нийтийн радио телевиз сонгуулийн сурталчилгааны мэдээг дохионы хэлээр хүргэж байснаас гадна

⁷ Олон улсын сонгуулийг ажиглах хороо Монгол Улс – Ерөнхийлөгчийн сонгууль, 2017 оны 6-р сарын 26 <https://www.osce.org/mn/odihr/327166?download=true> сүүлд үзсэн 2019.1.10.

⁸ Мөн тэнд. /2009 оноос хойш Монгол Улс нь НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид (ХБХЭТК) нэгдэн орсон. Үндсэн хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үл ялгаварлан гадуурхахыг зөвхөн ерөнхий зарчмаар хангаж, харин баталгаатай арга хэмжээгээр зааварчлаагүй байдаг. 2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар болон бусад холбогдох хуулийн заалтуудаар улс төрийн оролцоонд хамаарах зохих хамгаалалт, нөхцөлөөр ханган өгсөн./

зарим нэр дэвшигчид сурталчилгааны мэдээлэлдээ дохионы хэл ашиглажээ.⁹

СтХ-иар хөгжлийн бэрхшээлтэй сонгогч нь өөрийн сонгосон хүнээр туслуулан саналын хуудсыг тэмдэглүүлж болно. Түүнчлэн санал авах байруудыг харааны бэрхшээлтэй сонгогч уншиж болохуйц санал өгөх зааварчилгаа байлгаж, санал өгөхөд тохиромжтой бүхээг зэргээр тоноглогдсон байхыг заасан байдаг. Олон улсын ажиглагчдын хорооны очиж ажигласан санал авах байруудад энэ заалтуудыг дагаж мөрдсөн байсан. Хэдийгээр СтХ-иар санал авах байрууд нь тэргэнцэртэй сонгогчдод орох нөхцөл боломжоор хангагдсан байх ёстой гэж заасан боловч ихэнх нь хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс орох боломжгүй байшин барилга дотор байрлаж байв.¹⁰ Иймд, бүх нийтийн сонгууль, санал асуулга зохион байгуулах нь аливаа улсын хувьд их хэмжээний төсөв хөрөнгө шаардсан, сайн зохион байгуулж хэрэгжүүлбэл зохих үндэсний хэмжээний том арга зам. Санал өгөх байр хэдийг хаана бэлтгэх, хэдэн хүн ажиллуулах, ямар материал шаардлагатай зэргийг нарийвчлан тооцож гаргах нь зардлаа бууруулах боломж олгоно. Мөн ажилтнуудын ажил үүргийн хуваарийг нарийвчлан тогтоож, нарийн зохион байгуулж чадвал үйл ажиллагааны чанарт нөлөө үзүүлэхгүйгээр сонгуулийн ажлыг зохистой болгож болох юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллагуудын тооцоолсноор хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын 90 хүртэлх хувь нь санал авах байранд очиж саналаа өгөхийн оронд зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөхийг илүүд үздэг ажээ. Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зөөврийн хайрцгаар саналаа өгөх боломжийг олгож буй нь иргэний болон сонгуулийн эрхийг нь хангаж байгаа ч, зарим тохиолдолд үүнийгээ санал авах байрыг тэдэнд орох боломжтой болгож чадаагүй шалтгаанаа тайлбарлахад ашиглаж байсан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сонгуулийн үйл явцад бусад иргэдтэй адил оролцох нөхцөлийг бүрдүүлсэнгүй.¹¹ Үүнээс үзэхэд төслийн дээрх заалтуудыг практикт хэрэгжүүлэх субъект нь тодорхойгүйгээс хэрэгжих боломж нь хязгаарлагдмал байсан гэж үзэж байна.

2. Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж байгаа эсэх.

Монгол Улс нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах тухай НҮБ-ын конвенцид 2009 оноос нэгдэн орсон. Үндсэн хуулиндаа “ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн ерөнхий зарчмыг тусгасан хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухайд тусгайлан заалт байдаггүй. 2016 оны 2-р сард батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг ханган, улс төрийн байгууллагуудад сонгуулийн сурталчилгаагаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох, мөн тэдний нэр дэвших эрхийг дэмжих зэрэг үүргийг оруулан заажээ.

⁹ Мөн тэнд.

¹⁰ Мөн тэнд. /Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагаас барагцаалж байгаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 90 хүртэлх хувь нь санал авах байранд очиж санал өгснөөс зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгөхийг хүсжээ. ХБХЭТК-ийн 29-р зүйлд улс орнуудад “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн үйл хэргийг хэрэгжүүлэхэд ялгаварлан гадуурхалгүйгээр бусадтай адил тэгш нөхцөлд үр ашигтай, бүрэн оролцох орчин нөхцөлийг идэвхтэйгээр сурталчилж, нийтийн үйл хэрэгт тэдний оролцоог урамшуулах”- ыг зөвлөсөн байдаг./

¹¹ Монгол Улс Хуудас: 25 Ерөнхийлөгчийн сонгууль, 2017 оны 6-р сарын 26 болон 7-р сарын 7-ны өдрүүд
ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны Тайлан.
<https://www.osce.org/mn/odhr/elections/mongolia/366136?download=true> сүүлд үзсэн 2019.1.10.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай¹² хуулийн 30.1-т Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна гэж, төслийн 14.18-д “Сонгуулийн хороог аюулгүй байдал хангасан ажиллах байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга хариуцна” гэж, 68.2-т “Тухайн хэсгийн харъяалагдах сум, дүүргийн Засаг дарга Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу санал авахад шаардлагатай дараах зүйлийг санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө бэлэн болгох үүрэгтэй. 1/ санал авах байр, 2/ сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах бүхээг, 3/ зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах бүхээг, 4/ суурин болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, 5/ сонгогчийн бүртгэлийн мэдээллийг ажиглагчид үзүүлэх дэлгэц, 6/ хууль тогтоомжид заасан бусад зүйл” гэж заасан нь тэргэнцэртэй сонгогчийг орох боломжийг ямар субъект хариуцан хэрэгжүүлэх талаарх зохицуулалтыг орхигдуулсан байна.

Хэдийгээр СтХ-аар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хүлээн зөвшөөрч, улс төрийн намуудад сурталчилгааны материалаа хүртээмжтэй болгох, мөн хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчдэд дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал өгөх эрхээ эдлэх боломжийг хөнгөвчлөн, санал авах байр нь тэргэнцэртэй сонгогчдод орох нөхцөл боломжоор хангагдсан байх, харааны бэрхшээлтэй сонгогч уншиж болохуйц санал өгөх зааварчилгаа байлгах, санал өгөхөд тохиромжтой бүхээг зэргээр тоноглогдсон байхыг зааж өгсөн хэдий ч ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны ажиглалт хийсэн санал авах байруудын 35 хувь нь л хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод орох боломжоор хангагдсан¹³ байна.

Иймд, СЕХ, Засаг даргын Тамгын газарт санал авах байрыг бэлтгэх тухай даалгасан зохицуулалтыг нарийвчлан хөгжлийн бэрхшээлтэй иргэд санал өгөх боломжтой байдлаар бэлтгэх зохицуулалтыг нэмж тусгах, хуулийн төслийн 68.4, 68.5-т заасан сонгогчийн эрхийг хангах төсөв болон үйл ажиллагааг зохион байгуулах субъектийг тодорхой болгох нь зүйтэй юм.

3.3. Ойлгомжтой байдал

Хуулийн төслийн зохицуулалт нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгаж тогтоосон болно.

Хүснэгт 4. Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ

№	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Санал
1.	“нэн даруй” гэсэн нэр томъёо бичигдсэн төслийн зохицуулалтууд /6.10, 18.2.3, 19.11,19.14, 45.17, 68.8, 75.4.1, 77.1.2,	Хуулийн төсөлд “нэн даруй” хэрэгжүүлэхээр заасан 16 заалт байх бөгөөд тэдгээрийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй байна. Улсын дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоолуудыг үзвэл	Явуулах үйл ажиллагааны төрлөөс хамаарч “нэн даруй” гэдэг нь өөр өөр байх

¹² Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2016 он, №9

¹³ ЕАБХАБ-ын АИХЭГ-ын Сонгууль Ажиглах Хязгаарлагдмал Хороо Хуудас 13, Монгол Улс, Ерөнхийлөгч сонгууль, 2017 оны 6-р сарын 26-ны өдөр, Урьдчилсан тайлан (2017 оны 5-р сарын 23-ны өдөр)

	77.5.2, 77.16, 77.17,79.1, 80.4/	хууль, түүний зохицуулалтаас хамаарч “нэн даруй” гэдгийг ойлгох хугацаа өөр байна. Тухайлбал, Иргэний хуульд заасан “нэн даруй” гэдгийг тухайн тохиолдолд мэдэгдэх боломжтой ердийн хугацаанд ¹⁴ ойлгохоор байгаа бол Прокурорын /хуучин/ тухай хуульд заасан “нэн даруй” гэдгийг 24 цагийн дотор ¹⁵ гэж ойлгохоор байна.	тул хугацааг нарийвчлан зохицуулах
2.	“итгэмжлэгдсэн ажилтан”-тай холбогдох зохицуулалтууд	Төслийн 20.10-т “Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын итгэмжилсэн ажилтан /цаашид “итгэмжлэгдсэн ажилтан” гэх/ нь сонгогчдын нэрийн жагсаалтыг хүргүүлсэн өдрөөс эхлэн сонгогчдын нэрийн жагсаалтыг хариуцан хэсгийн хорооны дэргэд ажиллана” хэмээн Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын итгэмжлэгдсэн ажилтныг төслийн бусад хэсэгт “итгэмжлэгдсэн ажилтан” гэх томьёоллоор оруулахаар хуульчилсан ч цаашид энэхүү товчилсон хувилбараар ороогүй, бүтнээрээ орсон, “улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан”, “иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан”, “иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан” гэх зэргээр ялгаатай томьёолсон нь ойлгомжгүй байдлыг үүсгэж байна.	Тус асуудлыг нэг мөр болгож хоёрдмол утгагүй томьёолох
3.	6 дугаар зүйлийн 6.3-т Сонгогч сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа өөрөө өгнө.	Ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож саналаа өгөх тухай заасан нь хөгжлийн бэрхшээлтэй буюу бичих, хөдөлгөөний бэрхшээлтэй этгээд саналаа хэрхэн өгөх нь ойлгомжгүй байна.	Ойлголтыг нэг мөр болгох
4.	6 дугаар зүйлийн 6.4-т Сонгогч сонгуульд оролцох эсэхээ бие даан шийдвэрлэх, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэн боловч албадан нөлөөлж, саад учруулахыг хориглоно.	Хориглосон заалтыг сонгуулийн үйл ажиллагааны зарчимд оруулсан нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна.	Ойлголтыг нэг мөр болгох
5.	6 дугаар зүйлийн 6.8-д Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хугацаа	“Иргэний хуульд заасан зарчмыг баримтална” гэсэн байгаагаас үзвэл	Ойлголтыг нэг мөр болгох

¹⁴ Улсын Дээд Шүүхийн 2010 оны 17 дугаар тогтоол (2010.06.22.) “Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”, <https://www.legalinfo.mn/law/details/178?lawid=178> (сүүлд үзсэн: 2018.12.26.)

¹⁵ Улсын дээд шүүхийн 2003 оны 02 дугаар тогтоол (2003.02.20.) “Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”, <https://www.legalinfo.mn/law/details/603> (сүүлд үзсэн: 2018.12.26.)

	тоолоход Иргэний хуульд заасан зарчмыг баримтална.	Иргэний хуульд хугацаа нь зарчим байх тухай заагаагүй байна.	
6.	6 дугаар зүйлийн 6.9-д Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчим нь сонгогч саналаа нууцаар гаргахад хамаарахгүй.	Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчимд сонгогч саналаа нууцаар гаргах эрхийг хамааруулсан байна.Энэ нь сонгох, сонгогдох эрх тусдаа байх бөгөөд сонгууль зохион байгуулах, сонгуулийн төв хорооны ил тод байдалтай хамаагүй юм.	Сонгууль зохион байгуулах ил тод байдлыг хангах гэж ойлголтыг нэг мөр болгох.
7.	6 дугаар зүйлийн 6.12-т Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах зорилт бүхий дүрэмтэй, улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй төрийн бус байгууллага нь сонгуулийн байгууллага, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ /мониторинг/, ажиглалт хийх, сонгогчдод сонгуулийн мэдлэг олгох, эрхээ эдлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх зэргээр сонгуулийг хуулийн дагуу, шударгаар явуулахад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах эрхтэй.	Улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй төрийн бус байгууллагын эрхийг үйл ажиллагааны зарчимд хуульчлан тусгасан нь ойлгомжгүй байдлыг үүсгэж байна.	Ойлголтыг нэг мөр болгох
8.	9 дүгээр зүйлийн 9.16-д Энэ хуулийн 9.7, 9.8, 9.9, 9.10, 9.12-д заасныг зөрчсөн төрийн албан хаагчийг төрийн албанаас хална.	9.10, 9.12 дахь заалтад иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид нөхөн сонгууль буюу ээлжит бус сонгуулийг товлон зарлах тухай заасан байтал төрийн албан хаагчийг төрийн албанаас халах тухай заалтад хамааруулжээ. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид нь төрийн албан хаагч биш тул ойлголтыг нэг мөр болгох.	Ойлголтыг нэг мөр болгох
9.	Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг	Төслийн дээрх заалтууд нь практикт хэрэгжихэд ойлгомжгүй байдлыг бий болгох боломжтой байна. Тухайлбал, төслийн 16.1-д “ Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, таваас долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нийтэд	Практикт сонгуулийн хороог байгуулахдаа тав эсхүл долоо гишүүнтэйгээр буюу сондгой тооны гишүүнтэйгээр

		<p>мэдээлнэ” гэсэн заалтаас үзвэл аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн даргаас гадна таваас долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж болохоор заасан учир сонгуулийн хороог зургаан гишүүнтэйгээр байгуулж болохоор харагдаж байна.</p> <p>2005 оны Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Тойргийн хороо нь суманд, шаардлагатай бол нийслэлийн дүүрэгт салбар хороог санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, 5, эсхүл 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, тойргийн хэмжээнд нийтэд мэдээлнэ” гэж,</p> <p>2011 оны Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 55-аас доошгүй хоногийн өмнө тойргийн хороог дарга, нарийн бичгийн дарга, сондгой тооны 7-13 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, улсын хэмжээнд нийтэд мэдээлнэ” гэж тус тус заасан байдаг.</p>	<p>байгуулдаг байх тул төслийн дээрх зохицуулалтыг маргаан дагуулахгүй байлгах үүднээс “таваас долоон гишүүнтэй” гэснийг “тав эсхүл долоо” гэж, “гурваас таван гишүүнтэй” гэснийг “гурав эсхүл тав” гэж, “зургаагаас найман гишүүнтэй” гэснийг “зургаа эсхүл найм” гэж өөрчлөн найруулах.</p>
10.	<p>20 дугаар зүйлийн 20.10-т Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас сонгуулийн хорооны үйл ажиллагаа болон хуралдаанд оролцох боломжгүй болсон бол энэ тухайгаа бичгээр болон бусад хэлбэрээр урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.</p>	<p>Урьдчилан мэдэгдэх хугацаа тодорхойгүй байна.</p>	<p>Урьдчилан мэдэгдэх хугацааг тодорхой болгох.</p>
11.	<p>20 дугаар зүйлийн 20.1-т Сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн улсын сан дахь сонгогчийн бүртгэлд үндэслэн үйлдэх бөгөөд түүнийг нягтлан шалгах, давхардлыг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгуулийн эрх бүхий иргэнийг бүртгэх, сонгогчдийн нэрсийн жагсаалт болон сонгогч шилжих, түүнтэй холбоотой гомдол шийдвэрлэх зэрэг ажлыг</p>	<p>Бүлэг болоод зүйлийн гарчигт “Сонгогчдын нэрийн жагсаалт” гэж бичигдсэн атал зүйлийн доторх хэсэгт “сонгогчдын нэрийн жагсаалт”, “сонгогчдын нэрсийн жагсаалт” гэсэн хоёр янзаар бичигдсэн байна.</p>	<p>Тус нэр томъёог нэг мөр болгох.</p>

	улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хэмжээнд зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангана.		
12.	21 дүгээр зүйлийн 21.1-т Сонгогч өөрийн болон өөрийн гэр бүлийн аль нэг гишүүний нэр сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн, сонгогчийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаарх гомдлоо улсын бүртгэлийн холбогдох байгууллагад санал авах өдрөөс арван дөрвөөс доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана.	Аливаа шалтгааны улмаас санал авах өдрөөс 14 хоногийн өмнө гомдол гаргаж чадаагүй сонгогчийн тухайд сонгох эрх нь зөрчигдөх юм.	Нэрийн жагсаалтад гомдол гаргахад хугацааг заах шаардлагагүй гэж үзэж байна.
13.	45 дугаар зүйлийн 45.14-д Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ хуулийн 40.9-т хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчсөн тохиолдолд радио, телевизийн үйл ажиллагааг зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар зогсооно. 40.15.Шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 31.1, 39, 40.1.8, 40.6-д хяналт тавьж ажиллана.	Хууль тогтоомжийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт “Хуулийн давхардал, зөрчил гарахаас сэргийлэх, ойлгож хэрэглэхэд хялбар болгох зорилгоор ... тухайн хуульд нэгэнт туссан асуудлыг дахин дурдах бол эшлэл хэрэглэнэ” гэж заасан. Харин төслийн холбогдох заалтуудаас үзвэл, Харилцаа холбооны зохицуулах хороо нь хуулийн зохицуулалтад хяналт тавихаар ойлгогдож байна.	“... 40.9 дэх хэсэгт заасан үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах” гэж буюу “... 31.1, 39, 40.1.8, 40.6 дахь хэсгийн заалтуудын хэрэгжилтэд тус тус хяналт тавьж ажиллах” гэж өөрчлөх.
14.	Төслийн 45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсэг.	Төслийн 45 дугаар зүйлд “Хууль бус сурталчилгааг хориглох” тухай зохицуулсан байх бөгөөд хориглох тухай зохицуулалтуудыг тусгасан хэрнээ төслийн 45.3-т “Төрийн улс төрийн албан хаагч сонгуулийн сурталчилгаанд оролцож болно” гэж заасан нь хориглосон заалтуудын дунд “болно” гэсэн зохицуулалтыг тусгасан төслийн бусад заалтуудын уялдаа холбоо, утга найруулгыг алдагдагдуулж ойлгомжгүй байдлыг бий болгож байна.	Ойлголтыг нэг мөр болгох
15.	74 дүгээр зүйлийн 74.2-т Ажиглагч дараах эрх эдэлнэ:	Төсөл дэх ажиглагчийн эдлэх эрхийг заасан зохицуулалт болох 74 дүгээр зүйлийн 74.2 дахь хэсгийн 74.2.2-т “санал	Хоёрдмол ойлголтыг залруулах

	74.2.2.санал авах, үйл ажиллагааг ажиглах	авах, үйл ажиллагааг ажиглах” хэмээн хооронд таслал тавьснаар ажиглагч нь үйл ажиллагааг ажиглахаас гадна санал авах эрхтэй гэж ойлгогдохоор байна.	үүднээс холбоо үгийн дундах таслалыг арилгах
16.	Төслийн 72 дугаар зүйлийн 72.17 дахь хэсэг	Төслийн 72.17-д “...14 хоногийн хугацаагаар баривчлах захиргааны шийтгэл ногдуулна” гэж заасан байх бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1.1-д “баривчлах шийтгэл” гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл, төсөлд захиргааны шийтгэл гэж заасан нь захиргаанаас баривчлах шийтгэл оногдуулах мэтээр ойлгогдож байна.	Иймд төслийн 73.17-д “баривчлах захиргааны шийтгэл” гэж заасныг “баривчлах шийтгэл” гэж өөрчлөн найруулах;

Түүнчлэн энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн¹⁶ 28, 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах байдлаар шалгасан.

Хүснэгт 5. Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
28.1.Хуулийн төсөл дараах бүтэцтэй байна: 28.1.1.хуулийн төслийн гарчиг; 28.1.2.хуулийн төслийн бүтцийн үндсэн нэгж болох зүйл; 28.1.3.зүйлийн доторх хэсэг; 28.1.4.хэсгийн доторх заалт; 28.1.5.заалтын доторх дэд заалт; 28.1.6.шаардлагатай бол бүлэг, дэд бүлэг, хэсэг, дэд хэсэг, анги.	41.5.Энэ хуулийн 41.3 дахь заалтад шүүх, прокурор, тагнуул, цагдаа, онцгой байдлын болон эмнэлгийн байгууллага хамаарахгүй гэж заасны “41.3 дахь заалтад” гэснийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.13 заасны дагуу “41.3 дахь хэсэгт” гэж өөрчлөх.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29 дүгээр зүйлийн 29.1.1-т Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй

¹⁶ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2015 он, №25

үзэл баримтлалтай уялдсан байх;	
29 дүгээр зүйлийн 29.1.2-т Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
29 дүгээр зүйлийн 29.1.3-т Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөл зохицуулах харилцаа, хүрээнээс хальсан зүйл судалгаагаар тогтоогдоогүй.
29 дүгээр зүйлийн 29.1.4-т Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29 дүгээр зүйлийн 29.1.5-д Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	<p>- Төслийн 20.6-д "... улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ээлжит сонгуулийн жилийн <i>наймдугаар сарын 15-ны өдрөөс өмнө хүргүүлнэ</i>" гэж заасан бөгөөд 20.6.6-д "цагдаагийн байгууллага <i>санал авах өдөр</i> зөрчлийн улмаас баривчлагдсан, саатуулагдсан, гэмт хэргийн улмаас цагдан хоригдсон сонгогчдын мэдээллийг" гэж тус тус заасан нь хоорондоо зөрчилдсөн байна.</p> <p>Учир нь төслийн 20.6.6-д заасан заалт нь цагдаагийн байгууллагын хувьд сонгуулийн санал авах өдөр /<i>Төслийн 9.2-т заасны дагуу "Ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн арвдугаар сарын эхний хагасын аль нэг ажлын өдөр байна"</i>/</p> <p>- Төслийн 20.8-д "Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.6.4, 20.6.5, 20.6.6-д заасны дагуу ирүүлсэн иргэдийн мэдээллийг үндэслэн тухайн цэргийн анги, нэгтгэл хамаарч байгаа сонгуулийн хэсэгт саналаа өгөх сонгогчдын нэрийн жагсаалтад тухайн сонгогчийг нэмж бүртгэн байнга оршин суугаа газрынх нь хаягийн дагуу бүртгэгдсэн сонгогчдын нэрийн жагсаалтаас хасах" тухай тусгасан байна.</p> <p>- Төслийн 21.3-т "Энэ хуулийн 21.2-т зааснаас бусад үндэслэлээр сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг хориглоно" гэж, 21.5-т "Санал авах өдрийг хүртэлх долоо хоногийн хугацаанд энэ хуулийн 21.2-т заасан ажиллагааг хийхийг хориглоно" гэж тус тус заасантай заалттай 20.8-д заасан зохицуулалт нь нийцэхгүй байна.</p> <p>- Төслийн 69.1-т "Дараах сонгогчийн саналыг түүний хүсэлт, эмнэлгийн магадлагаа эсхүл холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагар <i>санал авах өдрийн өмнөх өдөр</i> 09:00-20:00 цагийн хооронд авна:</p> <p>69.1.3-т "Зөрчлийн улмаас баривчлагдсан, эсхүл саатуулагдсан;</p> <p>69.1.4-т "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу <i>баривчлагдсан, цагдан хоригдсон</i>" гэж заасан нь</p>

	<p>20.6.6-т заасан этгээдээс санал авах боломжтой мэтээр ойлгогдож байна.</p> <p>Гэтэл 20.6.6-т заасан заалт нь <i>санал авах өдөр</i> зөрчлийн улмаас баривчлагдсан, саатуулагдсан, гэмт хэргийн улмаас цагдан хоригдсон сонгогчдын мэдээллийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх тухай зохицуулалт байгаа нь хоорондоо зөрчилдсэн байна.</p> <p>- Төслийн 6 дугаар зүйлийн 6.7-т сонгуулийн хугацааг санал авах өдөртэй уялдуулан жил, сар, хоног, цаг, минутаар тоолохоор зохицуулсан байтал төслийн 6.8-т “Энэ хууль өөрөөр заагаагүй бол хугацаа тоолоход Иргэний хуульд заасан зарчмыг баримтална” гэж заасан нь 6.7-д заасан хугацаа тоолох зохицуулалтыг тусгагдаагүй мэтээр ойлгоход хүргэж байгаа төдийгүй 6.7-т заалтыг үгүйсгэсэн хуулийн зөрчлийг бий болгож байна.</p>
<p>29 дүгээр зүйлийн 29.1.6-д Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;</p>	<p>Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.</p>
<p>29 дүгээр зүйлийн 29.1.7-д Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;</p>	<p>Төслийн 35.5. Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг эшлэсэн байх боловч аль заалтаас эшлэл хийж байгаа нь тодорхойгүй байна.</p> <p>Төслийн 58.1-т Нам нь Улс төрийн намын тухай хуулийг эшлэсэн байх боловч аль заалтаас эшлэл хийж байгаа нь тодорхойгүй байна.</p> <p>Төслийн 59.2-т Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг эшлэсэн байх боловч аль заалтаас эшлэл хийж байгаа нь тодорхойгүй байна.</p> <p>Төслийн 69.1.2-т Дайчилгааны тухай хуулийг эшлэсэн байх боловч аль заалтаас эшлэл хийж байгаа нь тодорхойгүй байна.</p> <p>Төслийн 86.2-т Эрүүгийн хуулийг эшлэсэн байх боловч аль заалтаас эшлэл хийж байгаа нь тодорхойгүй байна.</p>
<p>29 дүгээр зүйлийн 29.1.8-д Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;</p>	<p>Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.</p>
<p>29 дүгээр зүйлийн 29.1.10-т Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;</p>	<p>Бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулаагүй байна.</p>

<p>29 дүгээр зүйлийн 29.1.11-т Хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.</p>	<p>Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.</p>
<p>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага.</p>	
<p>30 дугаар зүйлийн 30.1.1-т Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;</p>	<p>Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.</p>
<p>30 дугаар зүйлийн 30.1.2-т Нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;</p>	<p>Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.</p>
<p>30 дугаар зүйлийн 30.1.3-т Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;</p>	<ul style="list-style-type: none"> - Төслийн 4.4, 19.1, 27.3-т “...олонхийн...” гэж заасны “олонхийн” гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт “олонхын” гэж бичсэнээр өөрчлөх. - Төслийн 6.7-д “Сонгуулийн хугацааг хугацааг санал авах өдөртэй уялдуулан жил, сар, хоног, цаг, минутаар тоолно” гэж заасны хугацааг гэж давхардаж бичигдсэн тул хасах. - Төслийн 6.10-т Сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажилтай холбогдуулан нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан шийдвэрийг гаргасан этгээд нь нэн даруй хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар нийтэд албан ёсоор мэдээлнэ гэж заасны мөрдөх “өөр гаргасан” гэж давхардаж бичигдсэн тул хасах. - Төслийн 9.6-т Энэ хуульд заасны дагуу сонгуулийг хойшлуулсан эсхүл зогсоосон бол тухайн нөхцөл арилсан тухай шийдвэр гарсаны дараа Улсын Их Хурал ажлын арван өдөрт багтаан ээлжит сонгуулийг товлон зарлана гэж заасны “гарсаны” гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт “гарсны” гэж бичсэнээр өөрчлөх. - Төслийн 9.11-т “Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургаадугаар сарын ...” гэж заасны “зургаадугаар” гэдгийг МУҮХ-д “зургадугаар” гэж бичсэнээр өөрчлөх. - Төслийн 9.11-т Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургаадугаар сарын гуравдах долоо хоногийн ням гарагт улс даяар нэгдсэн журмаар явагдана гэж заасны “гуравдах” гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт “гуравдахь” гэж бичсэнээр өөрчлөх. - Төслийн 10.2.1-т, 10.7-д “...програм...” гэж заасны “програм” гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт “программ” гэж бичсэнээр өөрчлөх. - Төслийн 12.2-т “...аймгийн төвийн баг болон аймгийн сум тус бүр нь...” гэж зааснаас “... аймгийн ...” гэдгийг хасах. - Төслийн 87.1, 16.2.15-т “харъяалах” гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт

“харьяалах” гэж бичсэнээр өөрчлөх.

- Төслийн 16.2.3-т, 17.3.3-т “...эцэг эхийн...” гэж заасны **эцэг эхийн** гэдгийг **эцэг, /эх/-ийн** гэж нэг мөр болгон өөрчлөх.

- Төслийн 20.21-т, 20.22-т, 20.23-т, 21.6-д, 21.7-д, 21.8-д, 74.2.10-д “...**Сонгогчдийн**...” гэж заасны “**Сонгогчдийн**” гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт “**Сонгогчдын**” гэж бичсэнээр өөрчлөх.

- Төслийн 23.1.3-т, 23.7-д “...**бүрт**...” гэж заасны “**бүрт**” гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт “**бүрд**” гэж бичсэнээр өөрчлөх.

- Төслийн 26.3.3-т “эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй байх” гэдгийг “хүлээлгээгүй” гэснийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт “хүлээгээгүй” гэж бичсэнээр өөрчлөх.

- Төслийн 32.1-д “сурталчилах” гэснийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт “сурталчлах” гэж бичсэнээр өөрчлөх.

- Төслийн 40.1-т Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь намын далбаа, уриа, таних **тэмдэгийг** сурталчилгааны явцад ашиглах эрхтэй гэж заасны “**тэмдэгийг**” гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт “**тэмдгийг**” гэж бичсэнээр өөрчлөх.

- Төслийн 42.3-т “Ухуулгын байрыг доор дурдсан зорилгоор ажиллуулна” гэснийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт “доор” гэдгийг “дор” гэж бичсэнээр өөрчлөх.

- Төслийн 43.22-т Энэ хуулийн 43.2, 43.5-43.8, 43.12-43.16-д заасныг зөрчсөн хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван нэгээс арван зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, 43.11-д заасныг зөрчсөн телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо **цуцлана** гэж заасны “**цуцлана**” гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт “**цуцална**” гэж бичсэнээр өөрчлөх.

- Төслийн 45.14-т Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ хуулийн 45.9-т хяналт **тавиж** ажиллах бөгөөд зөрчсөн тохиолдолд радио, телевизийн үйл ажиллагааг зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар зогсооно гэж заасны “**тавиж**” гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт “**тавьж**” гэж бичсэнээр өөрчлөх.

- Төслийн 3.1.7-д “Монгол Улсын Үндсэн хуулийн хорин нэгдүгээр зүйлийн” гэсний “хорин” гэдгийг “Хорин” гэж бичих. Төслийн 9.13-т, 20.22-т “...сонгуулийн ерөнхий хороо” гэж заасан байна. “Сонгуулийн ерөнхий хороо” гэдэг нь оноосон нэр учир том үсгээр эхэлж бичнэ. “Сонгуулийн ерөнхий хороо” болгож засах.

- Төслийн 3.1.3, 9.10, 38.4-т “...сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн...”, “сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид” гэж өөр өөр бичсэн байгааг “*Иргэдийн*” гэдгийг Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” гэж заасан байх тул “*иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгч*” гэж хуулийн төсөлд жижиг, том үсгээр ижил бичих.

- Монгол хэлний зөв бичих дүрмийн дагуу дараах тийн

ялгалын нөхцөлийн зөв болгож өөрчлөх. Үүнд:

Төслийн 43.4-т заасан "...23.13-д..." гэснийг "...23.13-т..." гэж;
Төслийн 6.13-т заасан "...6.12-д..." гэснийг "...6.12-т..." гэж;
Төслийн 6.14-т заасан "...6.4-д..." гэснийг "...6.4-т..." гэж;
Төслийн 9.15-т заасан "...9.12-д..." гэснийг "...9.12-т..." гэж;
Төслийн 9.16-д заасан "...9.12-д..." гэснийг "...9.12-т..." гэж;
Төслийн 13.6-д заасан "...13.1-д..." гэснийг "...13.1-т..." гэж;
Төслийн 14.7-д заасан "...16.1-д..." гэснийг "...16.1-т..." гэж;
Төслийн 14.20-д заасан "...14.13-д..." гэснийг "...14.13-т..." гэж;
Төслийн 17.4-т заасан "...17.3.13-д..." гэснийг "...17.3.13-т..." гэж;
Төслийн 14.20-д заасан "...14.13-д..." гэснийг "...14.13-т..." гэж;
Төслийн 14.23-т заасан "...14.16-д..." гэснийг "...14.16-т..." гэж;
Төслийн 16.3-т заасан "...16.2.12-д..." гэснийг "...16.2.12-т..." гэж;
Төслийн 17.4-т заасан "...17.3.13-д, 17.3.10-д..." гэснийг "...17.13.13-т, 17.3.10-т..." гэж;
Төслийн 21.2-т заасан "...21.1-д..." гэснийг "...21.1-т..." гэж;
Төслийн 25.4-т заасан "...25.4-д..." гэснийг "...24.4-т..." гэж;
Төслийн 28.5-д заасан "...28.3-д..." гэснийг "...28.13-т..." гэж;
Төслийн 30.1.7-д заасан "...45.1-д..." гэснийг "...45.1-т..." гэж;
Төслийн 31.2-т заасан "...31.1-д..." гэснийг "...31.1-т..." гэж;
Төслийн 36.16-д заасан "...36.4-д..." гэснийг "...36.4-т..." гэж;
Төслийн 36.7-д заасан "...36.4-д..." гэснийг "...36.4-т..." гэж;
Төслийн 43.11-т заасан "...43.10-д..." гэснийг "...43.10-т..." гэж;
Төслийн 44.5-т заасан "...44.4-д..." гэснийг "...44.4-т..." гэж;
Төслийн 45.13-т заасан "...45.1-д..." гэснийг "...45.1-т..." гэж;
Төслийн 45.14-т заасан "...45-т..." гэснийг "...45.9-д..." гэж;
Төслийн 48.3-т заасан "...48.1-д..." гэснийг "...48.1-т..." гэж;
Төслийн 52.9-д заасан "...52.1-д..." гэснийг "...52.1-т..." гэж;
Төслийн 57.4-т заасан "...57.1-д..." гэснийг "...57.1-т..." гэж;
Төслийн 63.4-т заасан "...63.1-д, 63.3-д..." гэснийг "...63.1-т, 63.3-т..." гэж;
Төслийн 69.17-т заасан "...69.4-д..." гэснийг "...69.4-т..." гэж;
Төслийн 71.3-т заасан "...71.1-д..." гэснийг "...71.1-т..." гэж;
Төслийн 71.13-т заасан "...71.11-д..." гэснийг "...71.11-т..." гэж;
Төслийн 77.5-т заасан "...77.1.1-д..." гэснийг "...77.1.1-т..." гэж;
Төслийн 78.6-т заасан "...78.2-д..." гэснийг "...78.2-т..." гэж;
Төслийн 81.2-т заасан "...57.3-д..." гэснийг "...57.3-т..." гэж;
Төслийн 81.3-т заасан "...57.3-д..." гэснийг "...57.3-т..." гэж тус тус өөрчлөх.

- Төслийн 35.9-д "50-аас доошгүй" гэснийг "50-иас доошгүй" гэж өөрчлөн бичих.
- Төслийн 10.3.1-д "... санал авах үеийн хамгаалалт, хамгаалалт, шатахуун, техник хэрэгслийн зардал" гэж заасан зохицуулалтад давхардан бичигдсэн "хамгаалалт" гэдэг үгийг хасах.
- Төслийн 5 дугаар зүйлийн "...сонгох сонгогдох..." гэдгийн дунд таслал авах,
- Төслийн 72.2.2-т "тухайн санал авах байранд саналаа өгөх эрхгүй гэдгээ мэдсээр байж санал өгөх, эсхүл өөр хүний баримт бичиг, эсхүл хуурамч баримт бичиг ашиглах зэргээр санал өгөх, санал өгөхийг оролдох" гэж заасан зохицуулалтад давхардан бичигдсэн "эсхүл" гэдэг үгийг хасах.

30 дугаар зүйлийн 30.1.4-т Хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30 дугаар зүйлийн 30.1.5-д Жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

3.4. Харилцан уялдаа

Төслийн харилцан уялдаа холбоог шалгах шалгуур үзүүлэлтийн хүрээнд давхардал, хийдэл, зөрчлийг судлан, дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараах асуудлыг тодорхойлох байдлаар төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

Хүснэгт 6. Харилцан уялдаатай эсэхийг үнэлсэн байдал.

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн зорилтод сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан байх тул хуулийн төслийн 5 дугаар зүйл, 8 дугаар зүйл нийцэхгүй байна.
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх,	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	<p>- Төслийн 36 дугаар зүйлийн 36.7 дахь хэсэгт “Энэ хуулийн 36.1, 36.4-д заасныг зөрчсөн нь радио, телевизийн байгууллагын үйл ажиллагааг Харилцаа холбооны зохицуулах хороо зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар зогсооно”; 40 дүгээр зүйлийн 45.1.4-т “Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ хуулийн 45.9-т хяналт тавиж ажиллах бөгөөд зөрчсөн тохиолдолд радио, телевизийн үйл ажиллагааг зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар зогсооно” гэж тус тус заасан. Гэтэл Харилцаа холбооны тухай хууль¹⁷ /цаашид “ХХТХ” гэх/-д “зогсоох” гэсэн үгийг гагцхүү хэрэглэгч, үйлчлэгчид хамааруулан ойлгохоор хуульчилсан. Харин Харилцаа холбооны зохицуулах хороонд “түдгэлзүүлэх”, “хүчингүй болгох” гэсэн үгийг хамааруулан ойлгодог. Иймд төсөлд заасан “зогсооно” гэснийг “түдгэлзүүлнэ” гэж өөрчлөн найруулах;</p> <p>- Төслийн 43 дугаар зүйлийн 43.21, 43.22-т телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо <i>цуцлахаар</i> заасан. Гэтэл ХХТХ болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд /цаашид “ААҮАТЗтХ” гэх/-д тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох түтгэлзүүлэх тухай зааснаас цуцлах тухай заагаагүй байх тул ойлголтыг нэг мөр болгох зүйтэй юм.</p> <p>- Төслийн 10.1.14-д энэ хуулийн 47.2-т заасан мөнгөн урамшууллын зардал Хуулийн төслийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Сонгуулийн зардал нь дараах хөрөнгөөс бүрдэнэ:</p> <ul style="list-style-type: none"> • 47.2.1. хандив; • 47.2.2. намын өөрийн хөрөнгө; • 47.2.3. нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө” гэж заасан нь мөнгөн урамшуулалд хандив орохгүй байх тул нэр

¹⁷ Төрийн мэдээлэл эмхэтгэл (2001), №43

	<p>томъёоны хувьд нийцэхгүй байна.</p>
<p>Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх</p>	<ul style="list-style-type: none"> - Хуулийн төслийн 55 дугаар зүйлийн 55.1-т Мөнгөн хандив нь ...хуулийн этгээдийн хувьд арван таван сая төгрөг хүртэл байна, 55.2-т хуулийн этгээд нь нам, эвсэлд эсхүл нэр дэвшигчид жилд нэг удаа хандив өгч болно” гэж заасан бол 55.7-т “Хуулийн этгээд бэлэн мөнгөөр хандив өгөх, хуулийн этгээдээс бэлэн мөнгөөр хандив авахыг хориглоно” гэсэн зүйлийн заалттай нийцэхгүй байна. - Хуулийн төслийн 44.2-т сонгуулийн сурталчилгааны цахим хуудсаас бусад цахим хуудсаар <i>сурталчилгаа явуулж болох</i> талаар тусгасан бол төслийн 45.4.18-д сонгуулийн сурталчилгааны цахим хуудаснаас бусад хэлбэрээр <i>цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглосон</i> байна. Иймд эдгээр заалт өөр хоорондоо нийцэхгүй байна. - Төсөлд нийт 58 зүйл, заалтад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамаарч торгууль оногдуулахаар заасан байна. /5.7, 6.14, 9.15, 13.10, 14.19, 14.20, 14.21, 14.23, 16.3, 17.4, 19.23, 20.24, 21.9, 28.5, 33.8, 34.4, 36.5, 36.6, 37.5, 38.14, 39.10, 40.3, 41.6, 42.4, 44.5, 44.9, 45.12, 45.13, 47.6, 49.4, 50.13, 51.4, 52.9, 55.9, 55.10, 55.11, 56.5, 56.6, 62.6, 63.4, 64.4, 68.12, 69.16 69.17, 71.13, 71.14, 72.16, 73.13, 74.4, 75.6, 76.3, 77.18, 78.6, 79.4, 81.6, 82.4, 84.6, 85.4/ - Хуулийн үүрэгжүүлсэн, хориглосон зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг (санкци) хуулийн төслийн 11 дүгээр бүлэгт заасан хэдий ч дээрх зүйл заалт бүхэнд давхардуулан зохицуулжээ. 2017 оноос эхлэн дагаж мөрдөгдөх болсон Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиудад торгох ял, шийтгэлийг хуульчилж өгсөн байх бөгөөд ийнхүү хуульчлахдаа “нэгж” хэмээх ойлголтыг бий болгож, Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт Үндэсний хорооны шийдвэрээр (Засгийн газрын тогтоолоор) өөрчлөгдөж буй явдлыг зогсоох эрх зүйн үндэслэлийг бий болгосон юм. Иймд төслийн энэхүү зохицуулалтуудыг бусад хууль тогтоомжид хүлээлгэж буй хариуцлагын нэгэн адил, мөн хуулийн төслийн 11 дүгээр бүлэгт заасныг өөрчлөн сайжруулж зохих хариуцлагыг хүлээлгэх нь зүйтэй байна. - Төслийн 9 дүгээр зүйлийн 9.6-д “Энэ хуульд заасны дагуу сонгуулийг хойшлуулсан эсхүл зогсоосон бол тухайн нөхцөл арилсан тухай шийдвэр гарсны дараа Улсын Их Хурал <i>ажлын арван өдөрт багтаан</i> ээлжит сонгуулийг товлон зарлана” гэсэн заалт нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн /цаашид МУИХТХ гэх/ 30 дугаар зүйлийн 30.5-т “...Энэ хуулийн 30.2-т заасан онцгой нөхцөл арилсны дараа Улсын Их Хурал <i>ажлын 7 хоногт багтаан</i> ээлжит сонгуулийг товлон зарлана” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд төслийн 9 дүгээр зүйлийн 9.6-д заасан энэхүү заалтыг МУИХТХ-тай нийцүүлж, өөрчлөн найруулах нь зүйтэй. - Төслийн 45.1.4-т “бусдыг гүтгэн доромжлох, хуурамч мэдээлэл тараах”-ыг хориглохоор заасан бөгөөд 45.13-т “Энэ хуулийн 45.1-д заасныг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван нэгээс арван зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний

	<p>төгрөгөөр, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох"-оор заасан бөгөөд энэхүү заалтад заасан бусдыг гүтгэх доромжлох, хуурамч мэдээлэл тараах нь <i>Зөрчлийн тухай хуулийн</i> 6.21 дүгээр зүйлд "Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэж заасан "Гүтгэх" зөрчлийн шинжийг мөн агуулж байна. Энэ тохиолдолд хэрэв төсөлд зааснаар хариуцлага оногдуулбал иргэнийг 320.000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 3.520.000-5.120.000 төгрөгөөс, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтныг 1.920.000-2.560.000 төгрөгөөр тус тус торгохоор байна.</p> <p>Харин Зөрчлийн тухай хуульд зааснаар дээр зөрчлийг үйлдсэн хүнийг 2.000.000 төгрөгөөр, хуулийн этгээдийн 20.000.000 төгрөгөөр торгохоор хуульчилсан байна. Иймд төслийн 45.1-д заасан бусад заалтуудаас мөн Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх боломжтой заалтуудыг хуулийн давхардал үүсгэхгүй байлгах үүднээс Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэхээр зохицуулах нь зүйтэй.</p> <ul style="list-style-type: none"> - Төслийн 5.8, 6.15, 14.21, 19.24, 87.4-т заасан заалтууд нь 2019 оны 1 сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөгдөж буй Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.4-т "...төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах" гэж заасантай нийцэхгүй байна. Учир нь төслийн дээрх заалтуудад "төрийн албанд нэг жил, ... хоёр жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах"-аар тусгасан. - Хуулийн төслийн 5 дугаар зүйлд Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийн тухай заасан байтал 5.2-т эрхийг хязгаарласан, 5.4, 5.5-т хориглосон зохицуулалт, 5.7, 5.8-т хуулийн санкцийг заасан зүйлийн нэртэй нийцэхгүй байна. - Хуулийн төслийн 19.14-т "...саад учруулахыг хориглоно. Хуралдааны хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан этгээдийг хуралдаанаас нэн даруй гаргана." гэж тусдаа зохицуулж болох заалтыг нэг дор оруулсан байна.
<p>Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх</p>	<ul style="list-style-type: none"> - Хуулийн төслийн 4.1 дэх хэсэгт заасан "саналаа нууцаар гаргах" эрхийг 5.6 дахь хэсэгтэй агуулгын хувьд давхардуулан зохицуулсан байна. - Төслийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсэг нь мөн төслийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.5 дахь хэсэгтэй хэлбэр болон агуулгын хувьд давхцсан ба үүнтэй холбоотойгоор тус зүйлүүдэд хамаарах санкцийн зохицуулалт мөн давхардсан. Тодруулбал, дурдсан зүйлүүд нь сонгогчийн шууд сонгох эрх болон саналаа нууцаар гаргах эрхийн тухай зохицуулалт бөгөөд тус эрхээ эдлэхэд санаатайгаар саад учруулсан бол 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдийг ялгаатай хэмжээний төгрөгөөр торгохоор, 6 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасны дагуу аливаа этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор тус тус заажээ. Иймд нэг үйлдэлд ялгаатай шийтгэл оногдуулахаар зохицуулсан байх тул давхардлыг арилгах. - Төслийн "Хууль бус сурталчилгааг хориглох" хэмээх 45

	<p>дугаар зүйлд хориглосон үйл ажиллагааг жагсаахдаа мөн зүйлийн 45.1.7, 45.1.9-г давхардуулан хуульчилсан.</p> <ul style="list-style-type: none"> - Төслийн 71 дүгээр зүйлийн 71.13 болон 71.14 дахь хэсгийн санкцууд хоорондоо давхардсан байна. Учир нь 71 дүгээр зүйлийн 71.13-т “Энэ хуулийн 71.11-д заасныг зөрчсөн ... тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”; 71.14-т “Энэ хуулийн 71 дүгээр зүйлд заасныг зөрчсөн этгээдийг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж тус тус заасан. Үүнээс үзвэл 71 дүгээр зүйлийг зөрчсөн тохиолдолд бүхэлд нь санкци тогтоосон байтал 71.11 дахь хэсэгт хамааруулан дахин тусдаа санкци бий болгон давхардуулсан байна. - Төслийн 77 дугаар зүйлийн 77.16 дахь хэсэг болон 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, мөн төслийн 77 дугаар зүйлийн 77.17 дахь хэсгүүд нь хоорондоо хэлбэр, агуулгын хувьд яг адил байдлаар давхардсан байгааг засах. - Хуулийн төслийн зүйл, заалт нь Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн зүйл, заалттай давхардсан буюу нэр томъёог хууль бүрт ижил агуулгатай зохицуулсан байх тул давхардлыг арилгах.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Төслийн 20 дугаар зүйлийн 20.19-т “Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага <i>сонгогчдын нэрийн жагсаалт</i> үйлдэх, <i>танилцуулах</i> , давхардлыг шалгах, сонгогч шилжих журмыг энэ хуулийн 20 дугаар зүйлд нийцүүлэн батлан мөрдүүлнэ” гэж; мөн зүйлийн 20.23-т “ <i>Сонгогчдын нэрийн жагсаалтыг танилцуулах журмыг</i> улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн тагнуулын байгууллага батална” гэж чиг үүргийг давхардуулан хуульчилсан байна.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Төсөлд татвар, төлбөр хураамж шинээр тогтоосон зүйлгүй байна.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх	Төслийн 43 дугаар зүйлд “...телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо цуцлана” гэж заасан. ААҮАТЗтХ-д энэ тухай тусгасан боловч нэр томъёоны хувьд зөрчилтэй байна. /“цуцлах” гэж заасан байгааг “хүчингүй болгох, түтгэлзүүлэх” гэж/
Хуулийн төслийн зүйл, заалт нь жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Судалгаагаар жендэрийн эрх тэгш байдлыг хангасан байна.
Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Төслийн 38 дугаар зүйлийн 38.9-д “Орон нутгийн Хурлын төлөөлөгч сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа ээлжит сонгуулийн жилийн хоёрдугаар сарын нэгний өдрөөс өмнө тарааж

	болно. Үүнийг сонгуулийн сурталчилгааны материалын хэмжээнд тооцохгүй.” гэж заасан нь сонгуульд нэр дэвшсэн тохиолдолд түүнд давуу эрх эдлэн, өөрийн ажлыг тайлагнах замаар сонгуулийн сурталчилгаа хийж буй үйл ажиллагаа нь Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн байна.
Авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Төслийн 86 дугаар зүйлийн 86.3-т “Сонгуулийн үйл ажиллагааны явцад аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад эд хөрөнгийн болон бусад хохирол учирсан бол гэм буруутай этгээдэд холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэснийг үзвэл чухам ямар хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй байна. Учир нь эдийн болон эдийн бус хохирол учруулсантай холбогдох асуудлыг Иргэний хуулийг удирдлага болгон шийдвэрлэдэг. Иймд “Иргэний хууль болон бусад хууль” гэж өөрчлөн найруулах. Мөн үүрэгжүүлсэн, хориглосон зохицуулалтад хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хууль, бусад хуулиар тодорхой тусгах нь зүйтэй юм.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Үнэлэлт, дүгнэлт

1992 оны Монгол Улсын Үндсэн хууль батлагдсанаас хойш 27 жилийн хугацаанд сонгуулийн багагүй туршлагыг хуримтлуулж, холбогдох хуулиудыг өөрчлөх, шинэчлэх ажил хийгдэж байсан нь хамгийн сүүлд 2015 онд Сонгуулийн тухай хууль батлагдсанаар хэрэгжиж байна. Тус хуулийг УИХ-ын, Ерөнхийлөгчийн болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тусгайлсан хуулийн төслүүдийг боловсруулжээ.

Хуулийн төслүүдэд нийтлэг ажиглагдаж буй зарим сайжруулах шаардлагатай зохицуулалт цөөнгүй байна. Эдгээрийг аргачлалын дагуу сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр дүгнэвэл:

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн үзэл баримтлалд туссан үндсэн зорилгыг Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хөгжлийн хурдац, үүнээс үүдэн гарсан нөхцөл байдал, хууль тогтоомжийн чанарыг сайжруулахад чиглэсэн байхаар тодорхойлон, зорилгод хүрэхийн тулд дэвшүүлсэн зорилтуудыг дараах байдлаар тогтоосон.

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үндсэн зарчим, журмыг улам тодорхой болгох,
2. Тусгайлсан хууль боловсруулах,
3. Үндсэн хуульд заасан иргэний сонгох эрхийг хангах,
4. Сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн зорилтуудыг дэвшүүлжээ.

Эдгээр зорилтуудтай холбогдсон зүйл, заалтыг хуулийн төслөөс сонгон авч “зорилгод хүрэх байдал”-ын үр нөлөөг тооцож үзвэл, 1/ сонгуулийн үндсэн зарчим, журмыг улам тодорхой болгох зорилтын хүрээнд хуулийн төсөлд ил, тод байдлыг хангах, шударга ёсыг

сахих, сонгуулийн үйл ажиллагаа товлосон хугацаанд эхэлж, дуусах зэргийг товч тусгасан байх боловч зарчмын талаар тусгасан зохицуулалтад хориглосон зохицуулалт, сонгуулийн хугацаа, саналаа нууцаар гаргах эрх, үүрэгжүүлсэн зохицуулалт, ТББ эрх зэрэг хамааралгүй заалтыг оруулж өгсөн байна. Сонгуулийн төв байгууллагын журмыг тодорхой болгох тухайд 39 зүйл, заалтад “журмын” тухай заасан байгаа нь ямар журмыг тодорхой /хуулиа журам гэж байна уу, батлагдах журмыг хэлж байна уу, батлагдсан хэдий ч хэрэгжиж байгаад өөрчлөлт оруулах гэж байна уу гэдэг нь ойлгомжгүй/ болгох тухай нь ойлгомжгүй байна. Зорилгод хүрэх эхний зорилт тодорхойгүй, ойлгомжгүй байх тул зорилгод хүрсэн гэж үзэх үндэсгүй байна.

2/ Дараагийн зорилтод Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийг сонгуулийн харилцааны онцлогийг тусгасан, бүхэлд нь боловсронгуй болгох, Сонгуулийн тухай хуулиас тусгайлсан хуулийн төсөл боловсруулах талаар тусгасантай холбогдуулан төслийн 1 дүгээр зүйлд дүн шинжилгээ хийж үзлээ. 1 дүгээр зүйл буюу хуулийн төслийн зорилтод *сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулах* талаар заасан. Энэхүү хуулийн төслийн зорилт агуулгын хувьд УИХ-ын сонгуулийн тухай, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслүүдтэй ижил зохицуулагдсан.

Мөн Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан хуулийн зорилтод “сонгуулийн төв байгууллагын эрх зүйн байдал, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах талаар тусгасан байгаа нь хууль хоорондын давхардлыг үүсгэж байна.

Аливаа хуулийн зорилтод тухайн хуулиар зохицуулагдах харилцааны хамгийн товч хэлбэрийг тусгасан байдаг бөгөөд энэхүү хуулийн төслийн зорилтоос үзвэл *сонгуулийг зохион байгуулж явуулах тухай* зохицуулж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулиар заагдсан сонгох, сонгогдох эрх хэрхэн хангагдах, үндсэн зарчмыг хэрхэн тодорхой болгож байгаа нь ойлгомжгүй байна.

3/ Хуулийн төслийн 4.1, 5 дугаар зүйлд Үндсэн хуульд заасан иргэний сонгох эрхийг хангах талаар нийт 9 заалтад шууд утгаар тусгажээ. Харин 4 заалтад хориглосон, эрхгүй байх тухай, хариуцлагын заалтыг тусгасан байгаа нь зүйлийн нэртэй нийцэхгүй байгаа нь сонгох эрхийг хангах зохицуулалт туссан боловч зорилтод хүрсэн гэж үзэхгүй байна.

4/ Сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулахад Гуравдугаар бүлэг, 14-19 дүгээр зүйлд шууд утгаар туссан байх боловч хуулийн төслийн зорилтоос эхлэн ихэнх зохицуулалт зохион байгуулалтыг хангасан байх төдийгүй сайжруулахад нэлээд анхаарсан болохыг хэлэлцүүлэгт¹⁸ дурдаж байсан тул зорилтыг хангасан гэж үзэх үндэслэлтэй юм.

Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хангасан зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэхийг шалгасан. Ингэхдээ хуулийн төслийн 68.4, 68.5-т заасныг сонгон авч үзвэл “Санал

¹⁸ Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуулийн төслийн хэлэлцүүлгээс. УБ., 2018 он.

авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна”, “Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна” гэж заасныг ямар субъект хариуцан хэрэгжүүлэх талаарх зохицуулалтыг орхигдуулсан байна.

СЕХ, Засаг даргын Тамгын газарт санал авах байрыг бэлтгэх тухай даалгасан зохицуулалт байх боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэд санал өгөх боломжтой байдлаар бэлтгэх нарийвчилсан зохицуулалтгүй байна.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн ойлгомжтой байдлыг хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэх, Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын баримталсан эсэхийг шалгасан болно.

Хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг авч үзвэл нийт 29 зүйл, заалт ойлгомжгүй байна. Тухайлбал, Хуулийн төсөлд “нэн даруй” хэрэгжүүлэхээр заасан 16 заалт, итгэмжилсэн ажилтан /цаашид “итгэмжлэгдсэн ажилтан” гэх/ гэх зэргээр ялгаатай томъёолсон, ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож саналаа өгөх тухай заасан нь хөгжлийн бэрхшээлтэй буюу бичих, хөдөлгөөний бэрхшээлтэй этгээд саналаа хэрхэн өгөх нь ойлгомжгүй, хориглосон заалтыг сонгуулийн үйл ажиллагааны зарчимд оруулсан, “Иргэний хуульд заасан зарчмыг баримтална” гэсэн байгаагаас үзвэл Иргэний хуульд хугацаа нь зарчим байх тухай заагаагүй, Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчимд сонгогч саналаа нууцаар гаргах эрхийг хамааруулсан, Улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй ТББ-ын эрхийг үйл ажиллагааны зарчимд хуульчлан тусгасан, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид нөхөн сонгууль буюу ээлжит бус сонгуулийг товлон зарлах тухай заасан байтал төрийн албан хаагчийг төрийн албанаас халах тухай заалтад хамааруулсан гэх мэт заалтууд ойлгомжгүй байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага, мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг харгалзан үнэлэхэд төслийн зарим зүйл, заалт шаардлагад нийцээгүй болох нь тогтоогдож байна. Үүнд:

Төсөлд хоёрдмол утга агуулсан, давхардсан, хоорондоо зөрчилдсөн, нэр томъёоны хувьд өөр хоорондоо нийцэхгүй байдал үүсгэж буй, үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлээгүй байна. Тухайлбал, төслийн зарчмын талаар тусгасан зүйл байтал зүйлийн заалтад хориглосон, эрх олгосон, хугацаа заасан зэрэг заалт тусгасан, төсөлд “болно” гэсэн заалтын агуулгад хориглосон зохицуулалтыг оруулсан зэрэг байна.

Харилцан үялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн үр нөлөөг тооцох аргачлалын дагуу тодруулах шаардлагатай 14 төрлийн асуулгаас 4 төрлийн асуулга шаардлага хангасан байна.

Тухайлбал, шинээр албан татвар, төлбөр, хураамж тогтоосон зүйлгүй, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан, авилга хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгаагүй байна.

Шалгуур үзүүлэлтэд заасан 10 асуулгын хүрээнд хуулийн төслийн зарим зүйл, заалт харилцан уялдаа холбоотой байх шаардлага хангаагүй гэж үзлээ. Үүнд:

- Төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцээгүй, нэр томъёоны хувьд бусад хууль болон төсөлд тусгагдсан нэр томъёотой нийцэхгүй байх тохиолдол байна. Тухайлбал, ХХтХ-д тусгагдсан “түдгэлзүүлэх” гэснийг “зогсоох” гэж, “хүчингүй болгох” гэснийг “цуцлах” гэж төсөлд өөрөөр томъёолсон байна.

- Төсөлд тусгагдсан зүйл, заалт нь тухайн хуулийн төсөлд болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа байдлын хүрээнд, ТАтХ-д “3 жилийн хугацаагаар төрийн албанд эргэж орохгүйгээр халах” тухай зохицуулалт байхад төсөлд “1 жилийн хугацаагаар төрийн албанд эргэж орохгүйгээр халах” тухай өөрөөр зохицуулсан, төслийн 6 дугаар зүйлд сонгогч ямар нэгэн төлөөлөлгүйгээр саналаа өөрөө өгөхөөр зохицуулсан нь “бие эрхтний согог, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар санал өгч болно” гэж заасантай нийцэхгүй байна. Мөн төсөлд торгуулийн арга хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон нэмэгдүүлж авахаар тусгасан нь Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуультай нийцэхгүй байна.

- Хуулийн төслийн зүйл, заалтууд нь өөр хоорондоо болон бусад хууль, хуулийн төсөлтэй давхардсан зохицуулалт нэлээд байна. Хуулийн зүйл, заалт хоорондоо давхардсанаас гадна тусгаарласан хуулийн төслүүд хоорондоо давхардаж байна.

- Төсөлд сонгуулийн зардалтай холбоотой тусгасан зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага буюу торгуулийн хэмжээ хэтэрхий бага байна гэж дүгнэлээ.

4.2. Зөвлөмж

Хуулийн төслийн үр нөлөөг тооцох ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт хуулийн зорилтыг сонгох, сонгогдох эрхэд чиглэсэн байхаар томъёолох;
- Хуулийн төсөлд байгаа хоёрдмол утга агуулсан, давхардсан, хоорондоо нийцэхгүй байгаа ойлгомжгүй байдал үүсгэж буй зүйл заалтыг нэг мөр болгох;
- Хууль тогтоомжийн тухай хуулийн зохих шаардлагад нийцүүлэх;
- Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомж, төсөлд тусгагдсан зүйл, заалтуудыг нийцүүлэх, харилцан уялдааг хангах;
- Санал авах өдрийн санал авч эхлэх болон дуусах хугацааг дахин хянан авч үзэх;
- Сонгуулийн зардалтай холбоотой төсөлд тусгагдсан зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг нэмэгдүүлэх талаас нь анхаарах;
- Санал өгөх сонгогчийн тухайд зарим онцгой шалтгааны улмаас зайлшгүй төлөөлөгчтэй оролцох иргэдийн эрх ашгийг хөндөхгүйн тулд “бие эрхтний согог, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогчоос бусад сонгогчийн хувьд ямар нэг төлөөлөлгүйгээр саналаа өгөх” гэж тодруулах;
- Торгох ял, шийтгэлийн хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт Үндэсний хорооны шийдвэрээр /Засгийн газрын тогтоолоор/ өөрчлөгдөж буй явдлыг зогсоох эрх зүйн үндэслэлийг бий болгосонтой

торгуулийн арга хэмжээг нийцүүлэх.

- Сонгуулийн тухай хуулийг тусгаарлан хуулийн төсөл бэлтгэж байгааг дэмжиж байгаа боловч эдгээр хуулийн төслөөр /УИХ, Ерөнхийлөгч, АНСДИТХ/ тусгайлсан онцлог зохицуулалтыг тусгах буюу нэгэнт хууль боловсруулж байгаатай холбогдуулан Сонгуулийн тухай хуульд /ерөнхий хууль/ Сонгуулийн төв байгууллагын тухай хууль буюу үйл ажиллагаа, зохион байгуулалтыг зохицуулсан байгаа Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийг нэмж зохицуулан харин санхүүжилтийн асуудлыг тусдаа хуулиар зохицуулан сонгуультай холбоотой 5 тусгайлсан хуулийг боловсруулан давхардсан зүйлгүй ойлгомжтой энгийн байдлаар сонгох, сонгогдох эрхийг ханган, урт удаан хугацаанд тогтвортой үйлчлэх, сайн хуулийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Ном, гарын авлага

1. Ардчилсан сонгууль: Иргэний нийгмийн хяналт Уб., 2008
2. Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын институтийн гарын авлага Уб., 2008
3. Монгол Улс дахь үндсэн хуулийн процессийн тулгамдсан асуудал: хууль тогтоох, сонгуулийн төсвийн процесс: эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл Уб., 2013
4. Монгол Улсын анхны ардчилсан сонгууль 1990-2015 Уб., 2015
5. Монголын төр эрх зүй Уб., 2017
6. Сонгуулийн санхүүжилт:тулгамдсан асуудал ба шийдэл/судалгааны тайлан/Уб., 2015
7. УИХ-ын сонгууль 2008. Уб., 2008
8. УИХ-ын сонгууль-2012 “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээнээс хийсэн мониторинг. Уб., 2013
9. Сонгуулийн менежментийн хувилбарууд:ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын институтийн гарын авлага. Уб., 2008.
10. Сонгуульд суралцахуй тогтолцоо, үйл явц, эрх зүй. Уб., 2008
11. Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу? Уб., 2011
12. Сонгуулийн эрх зүйн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох ажлын хүрээнд хийсэн судалгаа/ судалгааны тайлан Уб., 2011
13. Улсын Их Хурал “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээнээс хийсэн мониторинг Уб., 2013
14. Б.Чимид. Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний Үндсэн хууль буруутай юу. Уб., 2011

Өгүүлэл, илтгэл

1. Ч.Содномцэрэн. Сонгуулийн зохион байгуулалт, тогтолцоо, түүнийг боловсронгуй болгох нь. Монгол улс дахь Үндсэн хуулийн процессийн тулгамдсан асуудал: хууль тогтоох, сонгуулийн болон төсвийн процесс:эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. Уб., 2013.
2. Д.Болд-Эрдэнэ. Сонгуулийн хэлбэрийн үйлчлэлийн асуудалд. Монгол улс дахь Үндсэн хуулийн процессийн тулгамдсан асуудал: хууль тогтоох, сонгуулийн болон төсвийн процесс:эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. Уб., 2013.
3. Д.Баасансүрэн. Ардчилсан сонгууль:олон нийтийн санаа бодол. Монгол улс дахь Үндсэн хуулийн процессийн тулгамдсан асуудал: хууль тогтоох, сонгуулийн болон төсвийн процесс:эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. Уб., 2013.
4. Б.Нармандах. Сонгох эрхийн хэрэгжилт, анхаарах зарим асуудал. Монгол улс дахь Үндсэн хуулийн процессийн тулгамдсан асуудал: хууль тогтоох, сонгуулийн болон төсвийн процесс:эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. Уб., 2013.
5. Д.Гангабаатар. Цахим саналын систем ба иргэдийн оролцоог нэмэгдүүлэх боломж. Монгол улс дахь Үндсэн хуулийн процессийн тулгамдсан асуудал: хууль тогтоох, сонгуулийн болон төсвийн процесс:эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. Уб., 2013.
6. Сонгогчдын боловсролд. Хүний эрхийн цуврал нийтлэл Уб., 2012.

7. Хариуцлагатай сонголтоор бид эрхээ баталгаажуулна. Хүний эрхийн цуврал нийтлэл УБ.,2013.

Цахим эх сурвалж

1. Олон улсын сонгуулийг ажиглах хороо Монгол Улс – Ерөнхийлөгчийн сонгууль, 2017 оны 6-р сарын 26 <https://www.osce.org/mn/odihr/327166?download=true> сүүлд үзсэн 2019.1.10
2. Монгол Улс Хуудас: 25 Ерөнхийлөгчийн сонгууль, 2017 оны 6-р сарын 26 болон 7-р сарын 7-ны өдрүүд ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны Тайлан. <https://www.osce.org/mn/odihr/elections/mongolia/366136?download=true> сүүлд үзсэн 2019.1.10.
3. Улсын Дээд Шүүхийн 2010 оны 17 дугаар тогтоол (2010.06.22.) “Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”, <https://www.legalinfo.mn/law/details/178?lawid=178> сүүлд үзсэн: 2018.12.26.